МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 1,
Утас: 33-07-90, 33-07-81, Факс: (976-11) 33-07-80
E-mail: info@cita.gov.mn, http://www.cita.gov.mn

2021.07.06 № 01/736

танай ____________-ны № ____________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Тус газрын Тогтоол, шийдвэрийн биелэлтийг 2021 оны хагас жилийн байдлаар гарган, хавсралтаар хүргүүлж байна.

ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны 7 дугаар сарын 06 -ны өдрийн 01/736 тоот бичгийн хавсралт

ТУ31739
5202965
1119288568

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**
**Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар**
**2021 оны хагас жил**

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | 1 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай 2011-06-16 Дугаар 2011.06.16 | 22.2. Энэ хуулийн 22.1.1-д заасан журмыг Засгийн газар батална. /22.1.1 энэ хуулийн 7 дугаар зүйл, 8.1 дэх хэсэг, 9, 10 дугаар зүйлд заасан мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн санг үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах нийтлэг журмыг боловсруулах;/ | Тус газраас 2021 онд Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, журмын төслүүд, Харилцаа холбоо, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрх олгох журмын төслүүдийг боловсруулсан. | 70% | | |
| | 2 | | 7.1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газар нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа – 2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавх, инновац үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн стратегийн зургаан том | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвлөгөөг баталсныг цахим хуудсандаа байрлуулсан. | | | |
| | 3 | | 7.1.2. Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Олон нийтээс санал, хүсэлт, өргөдөл гомдлыг цахим хуудсаараа https://www.cita.gov.mn/ дамжуулж авах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн info@cita.gov.mn цахим шууданг тус газрын Төлөвлөгөө, тайлан, өргөдөл гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэн хөтөлдөг бөгөөд энэ хаягаар дамжуулан байнга санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. | 100% | | |
| | 4 | | 7.1.3. Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газар нь иргэнд шууд хандсан үйлчилгээ үзүүлдэггүй болно. | 100% Хяналтаас хасуулах | | |
| | 5 | | 7.1.4. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа салбарын хууль тогтоомжууд, бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын мэдээллийг цахим хуудасны "хууль, эрх зүй" дэд цэсэд байрлуулан тухай бүр шинэчлэлт хийж байна. | 100% | | |
| | 6 | | 7.1.5. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | Тус газраас 2021 онд Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, журмын төслүүд, Харилцаа холбоо, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрх олгох журмын төслүүдийг боловсруулж нээлттэй санал авахаар байршуулсан. Мөн шинээр боловсруулж байгаа Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх олгох журмын төсөл болон аудит хийх аргачлалын төслийг байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулж, олон нийтээс санал авсан. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 7 | | 7.1.6. Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | Байгууллагын цахим хуудсанд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх "e-mongolia.mn" дэд цэсийг ажиллуулж байна. | 100% | | |
| | 8 | | 7.1.7. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | Тус газарт бусдаар гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн чиг үүрэг байхгүй болно. | 100% | | |
| | 9 | | 7.1.8. Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газар нь Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу "Тоон гарын үсгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл"-ийг олгодог бөгөөд одоогийн байдлаар тус тусгай зөвшөөрлийг 4 хуулийн этгээд авсан байна. | 100% | | |
| | 10 | | 7.1.9. Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх; | Цахим хуудасны "Ил тод" дэд цэстэй "Шилэн дансны цахим систем"-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнаж ажиллаж байна. | 100 | | |
| | 11 | | 8.1.1. Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; | Тус газраас сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажиллаж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 12 | | 8.1.2. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газрын даргын 2021 оны А/25 дугаар тушаалаар байгууллагын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн баталсан бөгөөд албан хаагчид Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдөн ажиллаж байна. | 100% | | |
| | 13 | | 8.1.3.. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А/37 дугаар тушаалаар "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг батласныг цахим хуудсандаа байршуулсан. | 100% | | |
| | 14 | | 8.1.4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон газрын батлагдсан орон тооны хүрээнд зохион байгуулалтын дотоод нэгжүүдийн албан тушаалын нэрс, орон тооны талаарх мэдээллийг нээлттэй байршуулсан. | 100% | | |
| | 15 | | 8.1.5. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | http://igovernment.mn/ хуудсанд байрлуулсан аргачлал, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 100% | | |
| 2 | 16 | Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-05-29 Дугаар 2017.01.01 | 49.1. Улсын Их Хурал, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, холбогдох бүтцийн нэгжийг ажиллуулна. | ЗГХЭГ-ын даргын 2021 оны 01 дүгээр тушаалаар тус газрын бүтцийг шинэчлэн баталсан ба бүтцээр Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс газрын даргын шууд удирдлагын дор ажиллаж байна. | 100% | | |
| 3 | 17 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3.. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж байна. | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 18 | Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29 | 9.12.. Олон улсын шуудан солилцооны үйлчилгээний тасралтгүй, шуурхай байдлыг хангаж, улсын хил, гаалиар түргэвчилсэн горимоор нэвтрүүлэх журмыг гаалийн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. | Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9.12-т заасны дагуу Олон улсын шуудан солилцооны үйлчилгээний тасралтгүй, шуурхай байдлыг хангаж, улсын хил, гаалиар түргэвчилсэн горимоор нэвтрүүлэх журмын төслийг боловсруулан Гаалийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монгол шуудан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагуудаас санал авч ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хуульд уг заалт өөрчлөн найруулагдсан болно. | 100% Хяналтаас хасуулах | | |
| | 19 | | 9.13.. Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | 1. Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/200,А/169 дүгээр хамтарсан тушаалаар "Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам"-ыг батлан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам, Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын төсөлд тус асуудалд хамаарах асуудлуудыг тусгасан. | 100% | | |
| 5 | 20 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ | 21.5.. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг | Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд гарган хяналт | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2020-05-07 Дугаар 2020.07.01 | жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | шинжилгээ, үнэлгээг хийж ЗГХЭГ-т хүргүүлээд байна. | | | |
| **УИХ-ын тогтоол** | | | | | | | |
| 6 | 21 | Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2011-12-15 Дугаар 02_2011_61 | 1. төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цахим хэлбэрт шилжүүлэх (тоон гарын үсгийн хэрэглээг нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах, төрийн болон төсөвт байгууллагыг техник хэрэгслээр хангах, холбогдох дүрэм, журмыг боловсруулах, мэдээллийг кодлох, цахим мэдээллийн сан бүрдүүлэх болон бусад арга хэмжээг хамааруулсан) төлөвлөгөөг боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлэх; | Тус газраас "Цахим засаглал" үндэсний хөтөлбөрийг боловсруулж МУЗГ-ын 2019 оны 73 дугаар тоот тогтоолоор батлуулж 2019-2020, 2021-2022 гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд төрийн мэдээлэл солилцооны ХУР системийг 2017 онд, цахим орчин иргэдийг таньж баталгаажуулах ДАН системийг 2018 онд, төрийн цахим үйлчилгээний e-mongolia.mn портал, аппликейшнийг 2020 оны 10 дугаар сард тус тус ашиглалтад оруулснаар цахим засгийн технологийн боломж бүрдсэн. Улмаар Концессоор хэрэгжүүлэх мэдээлэл, харилцаа холбооны төслүүдийг ЗГ-ын 2015 оны 411 дүгээр тогтоолоор, 2018 оны 259 дүгээр тогтоолоор төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн 496 үйлчилгээний жагсаалтыг, 2019 оны 23 дугаар тогтоолоор 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгон зарласан. Түүнчлэн, ЗГ-ын 2019 оны 149 дүгээр тогтоолоор Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа "Нэг цонхны үйлчилгээ", "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийг 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг "Үйлчилгээний нэгдсэн төв" болгон өөрчлөн зохион байгуулах, бүх сумдад "Үйлчилгээний нэгдсэн төв" байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасны үр дүнд төрийн захиргааны бүх | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шатанд цахим засгийг хөгжүүлж төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх үйл ажиллагаа хэрэгжиж байна. ЗГ-ын 2019 оны 220 дугаар тогтоол, 2020 оны 90 дүгээр тогтоолоор төрийн цахим үйлчилгээ цахим хэлбэрээр хүргэхэд төрийн мэдээлэл солилцооны ХУР систем, танилт баталгаажуулалтын ДАН систем, төрийн үйлчилгээний цахим систем www.e-mongolia.mn портал болон мобайл аппликэйшнийг ашиглахыг төр, захиргааны байгууллагад үүрэг болгон гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021 оны 6 дугаар сарын байдлаар төрийн үйлчилгээний цахим систем www.e-mongolia.mn сайт болон мобайл аппликэйшнээр дамжуулан 527 үйлчилгээг хүргээд байна. | | | |
| 7 | 22 | Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2018-06-21 Дугаар 2018 №54 | 1.2/. Төрийн мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, өгөгдөл хамгаалах, цахим засгийг бэхжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой арга хэмжээг судалж танилцуулах; | Цахим орчны хуулийн төслүүд боловсруулж байгаа болон “Нийтийн мэдээллийн тухай хууль”-ийн төсөлд төрийн байгууллагын мэдээллийн сангийн харилцааны зохицуулалт орж байгаа тул уг журмын төслийг нийцүүлэх шаардлагын үүднээс холбогдох судалгаа хийж байна. Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 11 сарын 09-ны өдрийн А/213 дугаар тушаалаар байгуулагдсан “Зам, тээврийн салбарт цахим шилжилт хийх, үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах чиглэл, зөвлөмж өгөх” ажлын хэсэгт ажиллаж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 23 | Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай 2020-04-09 Дугаар 2020 №21 | Дөрөв.4/. дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлж төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах, боловсролын алсын зайн сургалтын үйлчилгээг үзүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах хяналт бүхий цахим худалдааг дэмжих, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодод үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардлагатай үнэ, тарифын хөнгөлөлтийг үзүүлэх, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Тус газар нь Амазон компанитай хамтран онлайн худалдааны платформд Монгол бизнес эрхлэгчид бараа, бүтээгдэхүүнээ албан ёсоор борлуулалт хийх боломжийг бий болгосон. | 100% | | |
| 9 | 24 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай 2020-04-29 Дугаар 2020 №32 | 2.9/. Төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх; | Төрийн үйлчилгээний цахим машинаар 35 нэр төрлийн үйлчилгээг 304,332 иргэдэд хүргэн ажиллалаа. Төрийн үйлчилгээний цахим машинд үйлчилгээ нэмэх боломжтой үйлчилгээний жагсаалтыг ТҮЦ машины талаарх лавлах үйлчилгээний утсанд ирсэн санал, нэг цэгийн үйлчилгээнээс иргэдийн хамгийн их авдаг төрийн үйлчилгээний судалгааны дагуу боловсруулсан.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 49 дугаар захирамжаар цахим орчны эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргаар ахлуулан, ХЗДХ-ийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/225 тушаалаар "Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль"-ийг шинэчлэн найруулж "Нийтийн | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээллийн тухай хууль"-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийг тус тус байгуулсан. Эдгээр ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд төрийн мэдээлэл, мэдээллийн сан, цахим харилцаа, мэдээллийн ил тод байдлын харилцааг зохицуулах "Нийтийн мэдээллийн тухай хууль"-ийн төслийг боловсруулан хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2021-ний өдөр 2 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж иргэд, олон нийтийн саналыг авсны үндсэн дээр Засгийн газрын 2021 оны 3 дугээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн. Засгийн газраас гарсан шийдвэрийн дагуу уг хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр өргөн бариад байна. | | | |
| **УИХ-ын байнгын хорооны тогтоол** | | | | | | | |
| 10 | 25 | Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ | 2.3/. Төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай хамтран статистикийн мэдээллийн чанар, үнэн зөв байдалд хяналт шалгалт хийх, шат шатны хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах; | 1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын статистик тайлан мэдээний нэр төрөл, үзүүлэлтийг нэмэгдүүлэх, чанар, хүртээмж, хамрах хүрээг сайжруулах ажлын хүрээнд: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2019 оны А/72, А/145 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээр "Холбооны салбарын улсын тайлан, статистик мэдээний (давхардсан тоогоор 274 үзүүлэлттэй) маягт, түүнийг нөхөх заавар" -ыг боловсруулан Үндэсний статистикийн хорооны арга зүйн байнгын зөвлөлийн хурал болон Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ҮСХ-ны даргын А/32 тоот | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тушаалаар батлуулсан.<br>2. “Өрхийн болон хувь хүний Харилцаа холбоо мэдээллийн технологийн хэрэглээний судалгаа” хийх ажлын хүрээнд: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний статистикийн хорооны 2021 оны А63/А41 тоот тушаалаар хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлын үзэл баримтлал, зорилго, ач холбогдол, хамрах хүрээ, түүвэр, хүрэх үр дүнг боловсруулан, Үндэсний статистикийн хорооны арга зүйн байнгын зөвлөлийн хурал болон Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. 2021 оны 4-р улиралдаа багтаан судалгааны ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна | | | |
| 11 | 26 | Чиглэл өгөх тухай 2019-06-05 Дугаар 2019_05 "Цахим бодлогын түр хороо" | 1.1/. Төрийн үйлчилгээний цахим шилжилттэй холбоотойгоор урьд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, тэдгээрийн уялдаа холбоонд үнэлэлт, дүгнэлт хийж, нэгдсэн удирдлага, төлөвлөлтөөр хангах бүтцийг тодорхойлж танилцуулах; | 2020.01.22-ны өдрийн 1/70 тоот албан бичгээр Төрийн байгууллагуудаас мэдээллийн технологийн болон мэдээллийн технологийн чиглэлээр суурь судалгааны асуулгыг бэлтгэж хүргүүлж төрийн 41 байгууллагад хүргүүлснээс 32 байгууллагын мэдээллийг нэгтгэн ажиллалаа. Ерөнхий сайдын харьяа агентлагууд, Шадар сайдын харьяа агентлагууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 13 яам, түүний харьяа агентлагуудын хэмжээнд 98 харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн төсөл, 930.261 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр, аймаг орон нутагт 51 төсөл 153,676 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжиж байгаа тухай танилцуулгыг УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хороонд танилцуулсан. | 100% Хяналтаас хасуулах | | |
| | 27 | | 1.2/. Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, өгөгдөл хамгаалалтад мэдээллийн аюулгүй | Харилцаа холбооны тухай хуулийн 301 дэх хэсэгт заасан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байдлын аудит хийлгэж, нэгдсэн дүнг танилцуулах; | олгох журмын төсөл болон аудит хийх аргачлал, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын төслийг боловсруулж, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байрлуулж, олон нийтээс санал авч, төслийг газрын даргын тушаалаар батлуулсан. | | | |
| | 28 | | 1.3/. Төрийн байгууллагуудын мэдээллийн системийн уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах суурь үзэл баримтлалыг хувийн хэвшил, иргэний байгууллагын оролцоотойгоор боловсруулж батлах, түүнд үндэслэн цахим шилжилтийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг баталж шаардагдах төсвийг 2020-2022 оны улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх; | Мэдээллийн технологийн Интерактив ХХК, Интек ХХК болон их, дээд сургуулиудын эрдэмтдийн оролцооноос бүрдсэн зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан "Төрийн энтерпрайз архитектур"-ийг төрийн байгууллагуудад мөрдүүлэх ажил хийгдэж байна. ХЗДХЯ, ХХМТГ-аас хамтран боловсруулж 2021 оны 5 дугаар сарын 19-д УИХ-д өргөн барьсан "Нийтийн мэдээллийн тухай хууль"-ийн төсөлд төрийн энтерпрайз архитектурыг дагаж мөрдөх зохицуулалтыг тусгасан. | 70% | | |
| | 29 | | 1.4/. Интернэтийн дата хэрэглээний ачаалал, дотоод урсгалыг болон үндэсний контентын хэрэглээг нэмэгдүүлэх, Монгол Улсын иргэн бүрд дижитал үйлчилгээг хүргэх, хэрэглээг бий болгох зэргээр дижитал эдийн засгийг дэмжих төрийн бодлого, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх; | Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг сайжруулах зорилгоор тус газарт 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/19 тоот тушаалаар "Цахим ур чадвар, боловсролыг дэмжих" хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллав. Уг ажлын хэсгийн ажлын хүрээнд мэдээллийн технологийн суурь боловсрол, цахим ур чадварыг бий болгох анхан, дунд, ахисан болон төрөлжсөн сургалтын агуулгыг бэлтгэх ажлуудыг зохион байгуулж, сургалтын контентыг бүтээж, нэгдсэн платформд нэгтгэх арга хэмжээнүүдийг тусгаад байна. | 70% | | |
| | 30 | | 1.5/. Нэг иргэн, нэг бүртгэл хөтөлбөрийн хүрээнд төрөлжсөн бүртгэлийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн дугаарт үндэслэж | Иргэнийг цахим орчинд таних асуудлаар Тагнуулын ерөнхий газар болон бусад оролцогч байгууллагуудыг оролцуулан шийдэл боловсруулж Цахим хөгжлийн үндэсний хорооны хуралд танилцуулсан. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүртгэж, ашиглах асуудлыг судалж шийдвэрлэх; | Цахим хөгжлийн үндэсний хорооноос гарсан зөвлөмж, Эстонийн зөвлөхүүдээс ирүүлсэн зөвлөгөөний дагуу Дан танилт нэвтрэлтийн нэгдсэн системд тоон гарын үсэг, нэг удаагийн нууц үг ашиглах болон арилжааны банкны нэвтрэх эрхээ ашиглах боломжийг бүрдүүлж сайжруулалтыг хийж 2020 оны 10 дугаар сарын 01 өдрөөс хэрэглээнд нэтрүүлсэн. Иргэн өөрийн тоон гарын үсэг, эсвэл өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаараар нэг удаагийн нэвтрэх нууц үгээр баталгаажуулж, систем нэвтэрч байна. Уг системийг 38 байгууллага өөрийн системдээ, 149 мянга гаруй иргэн бүртгэл үүсгэн ашиглаж байна | | | |
| | 31 | | 1.6/. Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор улсын бүртгэлийн зарим үйлчилгээний талаарх мэдээллээр иргэдийг түргэн шуурхай хангахад үүрэн телефоны оператор компаниудын оролцоог нэмэгдүүлэх; | Иргэд 2020 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн төрийн үйлчилгээний цахим систем e-mongolia гар утасны аппликейшнийг ашиглан үйлчилгээ авахад дата төлбөргүй болох боломжийг үүрэн холбооны операторуудтай хамтран бий болгосон. | 100% Хяналтаас хасуулах | | |
| | 32 | | 1.7/. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх улсын бүртгэлийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх; | Цахим үйлчилгээний нэгдсэн системд улсын бүртгэлийн 24 лавлагаа, тодорхойлолт болон энгийн гадаад паспорт, иргэний үнэмлэх захиалах үйлчилгээ нэгтгээд байна. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Ухаалаг засаг төслийн санхүүжилтээр бүртгэлийн 30 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. | 100% | | |
| | 33 | | 1.8/. Төрөлжсөн бүртгэлийн суурь болох улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан, системийн аюулгүй, хэвийн ажиллагаа болон хууль тогтоомж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор улсын бүртгэлийн | Бүртгэлийн байгууллагын дэргэд мэдээллийн технологийн төвийн хэлбэрээр зохион байгуулалтын нэгжийг байгуулж ажиллуулах талаар судалж шийдвэрлэх нь Хууль зүй, дотоод хэргийн яамны асуудал болно. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын дэргэд мэдээллийн технологийн төвийн хэлбэрээр зохион байгуулалтын нэгжийг байгуулж ажиллуулах талаар судалж шийдвэрлэх; | | | | |
| | 34 | | 1.9/. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 25/16 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг Цахим бодлогын түр хороонд 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор танилцуулах; | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 25/16 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд нь Цахим бодлогын түр хороонд танилцуулсан. Яам, агентлаг, аймгуудын хэмжээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн тухай нэгдсэн мэдээллийг гаргах, дүн шинжилгээ хийх зорилгоор дараах асуулгын дагуу судалгааг 2019 оны 4 дүгээр сарын байдлаар авч, дүнг нэгтгэв. Судалгаа авсан асуулга:<br>- Төслийн нэр<br>- Эхлэх хугацаа /Он, сар, өдөр/<br>- Дуусах хугацаа /Он, сар, өдөр/<br>- Санхүүжилтийн эх үүсвэр<br>- Хөрөнгө оруулалтын төрөл<br>- Гэрээний дүн, мөнгөний төрөл<br>- Төслийн зорилго<br>- Хамрах хүрээ<br>- Хүлээгдэж байгаа үр дүн<br>- Хэрэгжилт (%-аар)<br>Ерөнхий сайдын харьяа агентлагууд, Шадар сайдын харьяа агентлагууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 13 яам, түүний харьяа агентлагуудын хэмжээнд 98 харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн төсөл, 930.261 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр, аймаг орон нутагт 51 төсөл 153,676 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжиж байна. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нэгтгэн үзвэл төрийн захиргааны төв болон 21 аймгийн хэмжээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нийт 149 төслийг 1,083.937 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. | | | |
| | 35 | | 1.10/. Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхолд харшлах цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний сөрөг мэдээллээс иргэдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний зөв | Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг сайжруулах зорилгоор тус газарт 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/19 тоот тушаалаар "Цахим ур чадвар, боловсролыг дэмжих" хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллав. Үйл | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохистой хэрэглээг сурталчлах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бүх нийтийн тоон бичиг үсгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх тодорхой төсөл, арга хэмжээг төлөвлөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020-2022 онуудад хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, хэрэгжилтийг эрчимжүүлэх; | ажиллагааны төлөвлөгөөнд нийт 92 арга хэмжээг төлөвлөөд байна. Нийт 18,2 тэрбум төгрөгийн төсвийн тооцоолол гарсан бөгөөд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн 2020-2022 онуудад хөгжүүлэх үндсэн чиглэлд холбогдох төслийн танилцуулга, төсвийг тусгаад байна. | | | |
| | 36 | | 1.11/. Цахим орчин дахь хууль бус контентын хандалтыг хязгаарлах, худал мэдээ, хуурамч хэрэглэгчийн бүртгэлийг устгах, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох, холбогдох байгууллагын чиг үүрэг, оролцоог оновчтой зохион байгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих, цахим орчны сөрөг үр дагавраас сэргийлэх, зохистой хэрэглээг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх; | 1. Нийгмийн мэдээллийн сүлжээний орчинд иргэн, хуулийн этгээдийн идэвхтэй ажиллуулж байгаа цахим хуудсыг хуурамч хуудаснаас ялгах хүсэлтүүд ихээхэн ирдэг болсонтой холбогдуулан тус газраас verified page буюу хэрхэн хөх тэмдэглэгээтэй болгох талаарх зөвлөмжийг боловсруулж, хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжүүдэд зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна.<br>2. Цахим орчинд хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил төлөвшилд сөрөг нөлөөтэй мэдээ, мэдээллээс үүсэн гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор ""Цахим орчинд хүүхэд хамгаалахад баримтлах чиглэл""-ийг боловсруулан ХХМТГ-ын Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, энэ чиглэлээр хамтран ажилладаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, НҮБ-ийн Хүүхдийн сан, БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газар, Нийслэлийн боловсролын газар, Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Хүүхдийн төлөө үндэсний | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөвлөл, ""Глоб Интернэшнл"" ТББ, Монголын сурагчдын холбоо, Монголын эцэг эхчүүдийн холбоо, Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, нийт 13 байгууллагуудад албан тоотоор хүргүүлсэн.<br>3. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Төрийн байгууллага, төрийн албан хаагч нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглах ерөнхий зөвлөмж”-ийг боловсруулж, тус газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, батлуулсан. | | | |
| | 37 | | 1.12/. Домейн нэрийн асуудлаар төрөөс баримтлах бодлогыг тодорхой болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх; | Харилцаа холбооны тухай хуулийн 2019 оны шинэчилсэн найруулгаар Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхэд домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавихыг тусгаж өгсөн. | 100% Хяналтаас хасуулах | | |
| | 38 | | 1.13/. Цахим орчин дахь хүүхдэд сөрөг нөлөөтэй контентыг тодорхойлох эрх бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, гомдлыг шуурхай шийдвэрлэх системийг бий болгох; | 1. “Цахим орчинд үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг хууль бус үйлдэл, түүний үндэсний болон олон улсын эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг судлах, үр дүнг хэлэлцэх” ажлын хүрээнд: “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-ийн тусгай дугаарт мессеж хүлээн авах, хариу өгөх зөвшөөрлийг олгоход дэмжлэг үзүүлж, ажилласан.<br>2. Насан туршийн боловсролын төвтэй хамтран "Цахим орчинд хүүхэд хамгаалал" сэдвээр хүүхэд, эцэг эхчүүдэд зориулсан цахим хичээл бэлтгэн телевиз, сошиал сувгуудаар түгээсэн. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 39 | | 1.14/. Цахим орчин дахь нийгмийн сүлжээнд хэрэглэгч утасны дугаараар бүртгүүлэхтэй холбогдох хууль тогтоомжийн төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Тус газрын даргын 2020 оны А/143 тоот тушаалаар гар утасны дугаарыг хэрэглэгчийн регистрийн дугаараар бүртгэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажлын хэсгийн хүрээнд цахим орчин дахь нийгмийн сүлжээнд хэрэглэгч утасны дугаараар бүртгүүлэхтэй холбоотой асуудлыг судалж байна. Мөн "Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль"-ийн төсөл цахим орчин дахь нийгмийн сүлжээнд хэрэглэгчийг баталгаажуулан бүртгэх зохицуулалтыг тусгасан. Уг хуулийн төслийг Улсын их хуралд өргөн мэдүүлсэн. | 100% | | |
| | 40 | | 1.15/. Хилийн чанадад амьдарч буй Монголчууддаа төрийн үйлчилгээг ойртуулах, цахимжуулах; | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "e-mongolia"-ын үйл явдал хэсэгт "Гадаад байгаа Монгол иргэн" цэсийг нээж тусгай үүргийн нислэг, хуваарьт тусгаарлан ажиглах байр, "e-mongolia" хэрхэн ашиглах заавар, тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам зэрэг мэдээ мэдээллийг оруулан 38 төрийн цахим үйлчилгээг үзүүлж байна. | 100% | | |
| | 41 | | 2.. Энэ тогтоолын биелэлтийн явцыг 2019 оны дөрөвдүгээр улиралд Цахим бодлогын түр хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай | Яам, агентлаг, аймгуудын хэмжээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн тухай нэгдсэн мэдээллийг гаргах, дүн шинжилгээ хийх зорилгоор судалгаа авч, дүнг нэгтгэсэн. Ерөнхий сайдын харьяа агентлагууд, Шадар сайдын харьяа агентлагууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 13 яам, түүний харьяа агентлагуудын хэмжээнд 98 харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн төсөл, 930.261 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр, аймаг орон нутагт 51 төсөл 153,676 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжиж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нэгтгэн үзвэл төрийн захиргааны төв болон 21 аймгийн хэмжээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нийт 149 төслийг 1,083.937 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа тухай танилцуулгыг УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хороонд танилцуулсан. | | | |
| **Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | | | |
| 12 | 42 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46 | 1.. Монгол бичгийн цахим кодыг хэрэглэх үндэсний стандартыг холбогдох мэргэжилтнүүдийн саналыг тусган шуурхай боловсруулж, хуульд заасны дагуу батлуулах, цаашид хөгжүүлэн тогтвортой байдлыг хангаж, цахим орчинд үндэсний хэрэглээг нэмэгдүүлэх талаар бодлого, төлөвлөгөө гарган ажиллахыг Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол хэлний тухай хуулиар үүрэг хүлээсэн эрх бүхий судалгааны байгууллагад; Үндэсний стандартыг боловсруулах ажилд хяналт тавьж, боловсруулсан стандартыг судалж батлах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, монгол бичгийн цахим кодчиллыг олон улсын стандартад үндэсний стандартыг хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол Улсын Шадар сайдад чиглэл болгосугай. | Зарлиг хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 95 дугаар захирамжаар БСШУСЯ, ШУА, Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Стандарт хэмжилзүйн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо болон монгол бичгийн кодчилол, монгол бичгийн программ хөгжүүлэлтийн зохих мэдлэг туршлага бүхий эрдэмтэн, судлаачдын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо 2018 оны 5 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол бичгийн кодчиллын юникодын стандартыг боловсронгуй болгох Монгол Улс, БНХАУ-ын ажлын хэсгийн төлөөлөгчдийн уулзалт, ӨМӨЗО-ны Хөх хотноо 6 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ӨМӨЗО-ны Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын сургуулиас зохион байгуулсан “Монгол бичиг, түүний юникод хөгжлийн өнөөгийн байдал” сэдэвт хуралд 2 төлөөлөгчийг тус тус томилон ажиллуулсан. Дээрх хурал, уулзалтын үр дүнд Монгол Улс, БНХАУ монгол бичгийн юникодын кодчиллыг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллах, хамтарсан саналыг Юникодын ажлын хэсгийн Монгол | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бичгийн юникодын ажлын хэсгийн 3 дахь удаагийн хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 3-5-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Юникод консорциум байгууллагатай хамтран зохион байгуулж монгол бичгийн юникодын стандартыг боловсронгуй болгох чиглэлийг тодорхойлсон. Хуралд нийт 50 орчим хүн оролцсон ба Юникод Консорциум байгууллагаас 5 хүн, ӨМӨЗО-ны 8 судлаач хүрэлцэн ирж оролцсоны дээр зайнаас АНУ, Япон, ӨМӨЗО-ны 4 судлаач оролцож санал, байр сууриа хуваалцсан. Монгол Улсаас нийт 40 гаруй хүн эрдэмтэн, судлаачид оролцсон. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга монгол бичгийн юникодын ажлын хэсгийн 3 дугаар хурлын үйл ажиллагаа болон хүлээгдэж буй үр дүнг талаар хурал зохион байгуулагчдын болон Юникод Консорциумын төлөөлөгчдийг 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр хүлээн авч монгол бичгийн кодчиллын авиазүйн загварыг боловсронгуй болгох, кодчиллын түвшинд үүсээд байгаа асуудлыг шийдвэрлэх талаар ахиц дэвшил гарч байгааг сайшаан дэмжсэн. | | | |
| | 43 | | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Тус газрын хаяг болон бусад баримт бичигт үндэсний бичгийн соёлыг хэвшүүлэхийн тулд эхний ээлжид бүх албан хаагчдад сургалт авах шаардлагатай байна. Энэхүү төлөвлөгөөт ажлыг 2021 оны 1 дүгээр улиралд хийхээр төлөвлөн ч цар тахалтай холбоотойгоор түр хугацаагаар хойшлуулсан. | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | 44 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.2.. Цахим орчинд тавих хяналтын тухай хууль тогтоомжийг шинээр боловсруулж, нийгмийн сүлжээнд Харилцаа холбооны зохицуулах хороо болон хууль сахиулах байгууллагаас хяналт тавьж, болзошгүй эрсдэлээс сэргийлж, IPTV болон нийтийн мэдээллийн хэрэгсэл, интернэтийн сүлжээнд шаардлагатай хязгаарлалтуудыг тухай бүр хийх зохицуулалтыг бий болгох. | 1. Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/200,А/169 дүгээр хамтарсан тушаалаар "Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам"-ыг батлан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам, Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын төсөлд тус асуудалд хамаарах асуудлуудыг тусгасан.<br>3. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5306 дугаарт, Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5060 дугаарт, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам 2020.11.05-ны өдрийн 4904 дугаарт тус тус бүртгэгдсэн болно. | 100% Хяналтаас хасуулах | | |
| 14 | 45 | Үндэсний зөвлөл байгуулах тухай 2019-12-24 Дугаар 2019_42 | 4.. Хариуцах ажлынхаа ерөнхий бодлого, чиглэлийг танилцуулж хөтөлбөр батлуулах болон хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан байнгын үйл ажиллагаатай хороо байгуулах асуудлыг Монгол Улсын Засгийн газраар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Үндэсний зөвлөлд үүрэг болгосугай. | Цахим засгийн төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулан зохион байгуулах үүрэг бүхий Цахим хөгжлийн үндэсний хороог Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 458 дугаар тогтоолоор байгуулсан. Уг Уг хороо нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан тус хорооны бүрэлдэхүүнд яамдын Төрийн нарийн бичгийн дарга, засгийн газрын агентлагийн дарга нараас бүрддэг. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Одоогийн байдлаар нийт дөрвөн удаагийн хуралдааныг зохион байгуулсан ба Хорооны даргын дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал:<br>1. Цахим танилтын системийн нэгдсэн шийдэл, шаардлагатай хууль эрх зүйн өөрчлөлт, тоон гарын үсгийг өргөн хэрэглээнд нэвтрүүлэх;<br>2. "Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль", "Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль", "Төрийн цахим харилцааны тухай хууль" зэрэг багц хуулийг өргөн барих;<br>3. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем И-Монгол хөгжүүлэлт, мөн хүнд суртал байж магадгүй төрийн бусад үйлчилгээг цахимжуулах боломж байгаа эсэх төлөвлөгөөг гаргаж, саналаа боловсруулах, тандалт судалгаа хийх;<br>4. Салбар бүр цахим шилжилт хийх төлөвлөгөөгөө гаргах;<br>5. Төв шуудан дээр иргэдэд мэдээлэл өгдөг төв байгуулах;<br>6. Үндэсний Дата төв дээрх ХУР төрийн мэдээлэл солилцооны системийг өргөтгөн сайжруулах. | | | |
| **ҮАБЗ-ийн зөвлөмж** | | | | | | | |
| 15 | 46 | Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай 2017-07-19 Дугаар 2017_19/5 | 1.. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах | Тус газар нь Монгол Улсын төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон урсгал төсвийг захиран зарцуулсан болно. Тус төсвийн зарцуулалтын Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө худалдаа авах тухай хуулийн дагуу цахим хэлбэрээр нээлттэй тендер шалгаруулалтын журмаар амжилттай зохион байгуулаад байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 47 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05 | 1.12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ил болон далд хэлбэрээр сурталчилсан хэвлэл мэдээллийн байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах, цахим сайт, хаягуудыг хориглох, ийм төрлийн сэдэвтэй гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, үйлдэх аргыг нарийвчлан харуулсан бүх төрлийн кино, нэвтрүүлэг, нийтлэл болон бусад уран бүтээлийг олон нийтэд хүргэхгүй байх арга хэмжээг тухай бүр авах. | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ил болон далд хэлбэрээр сурталчилсан хэвлэл мэдээллийн байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах, цахим сайт, хаягуудыг хориглох, ийм төрлийн сэдэвтэй гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, үйлдэх аргыг нарийвчлан харуулсан бүх төрлийн кино, нэвтрүүлэг, нийтлэл болон бусад уран бүтээлийг олон нийтэд хүргэхгүй байх арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна. Мөн нийгмийн мэдээллийн сүлжээгээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ил болон далд хэлбэрээр сурталчилсан мэдээ, мэдээлэл оруулсан тухай бүрд холбогдох байгууллагад хүсэлт гарган устгуулан ажиллаж байна. | 100% | | |
| 40 | 90 | Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай<br>2020-03-22<br>Дугаар 2020_102 | 4. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд даалгасугай. | Тус газраас ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг авч ажилласан. | 100%<br>Хяналтаас хасуулах | | |
| 41 | 91 | Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай<br>2020-03-25<br>Дугаар 2020_106 | 1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой | Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | | | | |
| | 92 | | 2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | | |
| | 93 | | 3. "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж, зохих журмын дагуу батлуулан хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Чинбат), Архивын ерөнхий газар (С.Энхбаатар)-т тус тус даалгасугай. | Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төсөл боловсруулагдаж, байгууллагуудаас санал авч байгаа бөгөөд тус газраас зохих саналуудаа тусгасан. | 70% | | |
| | 94 | | 4. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд албан хэрэг хөтлөлтийн программ хангамж нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Чинбат), Архивын ерөнхий газар (С.Энхбаатар)-т тус тус даалгасугай. | Засгийн газрын 2020 оны 42 дугаар тогтоол болон энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахаар тус газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын хамтарсан 04 сарын 24-ны өдрийн А/52/А-47 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, төрийн байгууллагад нийтлэг ашиглаж байгаа цахим албан хэрэг хөтлөлтийн систем, түүний үйл ажиллагааг шалган туршсан. Уг шалгалтаас гарсан үр дүнд тулгуурлан цахим баримт бичиг солилцооны дундын системийн бүтцийн зураглалыг гаргаж, систем хоорондын харилцан холболтын гарын авлагын | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төслийг боловсруулсан. Цахим баримт бичиг солилцооны дундын системийг Үндэсний дата төв УТҮГ-ын зохиомол серверт шилжүүлэн байршуулаад байна. Улмаар Төрийн захиргааны болон төрийн өмчийн, орон нутгийн захиргаа, түүний харьяа нийт 1206 байгууллага, нийслэлийн нутгийн захиргааны 1697 байгууллагын 30 мянга гаруй албан хаагчид албан хэрэг хөтлөлтийн системд ашиглаж, цахим хэлбэрээр баримт бичиг солилцох боломжтой болсон. Дээр дурдсан системтэй Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар хөгжүүлсэн DOCX албан хэрэг хөтлөлтийн дундын системийг холбох хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна. Албан хэрэг хөтлөлтийн системийн дундын системд холбогдсоноор цахим хэлбэрээр баримт бичиг түргэн шуурхай солилцох нөхцөл бүрдэж байна. | | | |
| 42 | 95 | “Боловсролын мэдээллийн технологийн төв” байгуулах тухай 2020-03-25 Дугаар 2020_111 | 3. “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийг “Үндэсний дата төв”-д байршуулж, тус мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Үндэсний дата төв (М.Баттулга) нарт даалгасугай. | “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийг “Үндэсний дата төв”-д байршуулж, тус мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. | 100% | | |
| 43 | 96 | БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ | 3.2. 3.2. Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг тэргүүн ээлжид санхүүжүүлэх: 3.2.1. бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны зардал; 3.2.2. бүх шатны төсвийн байгууллагын коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг | Тус байгууллагын цалин хөлс, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай зардлыг сар бүр тогтсон хугацаанд олгож ажиллав. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТУХАЙ<br>2020-03-27<br>Дугаар 2020_114 | хангахтай холбоотой бүх төрлийн зардал;<br>3.2.3. бүх шатны төсвийн байгууллагын цалин хөлс, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай зардал;<br>3.2.4. нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ. | | | | |
| | 97 | | 3.4. 3.4. Төсвийн урсгал зардлаас дараах зардлын санхүүжилтийг түр зогсоох:<br>3.4.1. бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх;<br>3.4.2. хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал;<br>3.4.3. цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр;<br>3.4.4. бараа үйлчилгээний бусад зардал. | Бэлэн байдлын өндөржүүлсэн зэрэгт шилжсэнтэй холбогдуулан байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрүүдийг бүрэн зогсоогоод байна. | 100%<br>Хяналтаас хасуулах | | |
| 44 | 98 | Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай<br>2020-04-22<br>Дугаар 2020_144 | 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай. | Тус газар нь өөрийн гэсэн байргүй учраас Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн байранд байрлан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дулаан, цахилгаан гэх мэт урсгал зардлыг улирал бүр тогтмол төлж барагдуулан ажиллаж байна. | 100%<br>Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | 99 | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<br>2020-04-29<br>Дугаар 2020_151 | 3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай. | Төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан тусгуулсан бөгөөд нийт 24 сая төгрөгийг албан хаагчид олгуулаад байна. Мөн төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг тухай бүр олгон ажиллаж байна. Үүнтэй уялдуулан Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд тус газрын саналыг тусгуулахаар ажиллаж байна. | 70% | | |
| 46 | 100 | Олон улсын байгууллагад гишүүнээр элсэх тухай<br>2020-05-06<br>Дугаар 2020_160 | 3. Монгол Улс "Харилцаа холбооны салбар дахь бүс нутгийн хамтын нийгэмлэг"-т гишүүнээр элсэх хүсэлтийг зохих журмын дагуу уламжлах, тус байгууллагын гишүүний татварыг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэж байхыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад даалгасугай. | Харилцаа холбооны салбар дахь бүс нутгийн хамтын нийгэмлэгт гишүүнээр элсэх хүсэлтээ албан ёсоор хүргүүлж, удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бүрэн эрхт төлөөлөгчөөр элссэн, үйл ажиллагаанд нь оролцож байна. Тус байгууллагын гишүүний татварыг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэж ажиллав. | 100% | | |
| 47 | 101 | Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай<br>2020-05-06<br>Дугаар 2020_163 | 3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрд өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай. | Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрд өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн www.hr.csc.gov.mn системд оруулж ажилласан. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 102 | КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2020-05-06 Дугаар 2020_168 | 3. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах замаар энэ тогтоолын 1 дэх заалтад заасан төсвийн зохицуулалтыг тусган баталж мөрдүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй. 3. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагааг зохион байгуулж төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх захирамжийн дагуу Монгол Улсын 2021 оны Төсөвт тодотгол хийхэд тус газрын урсгал хөрөнгө оруулалтын нийт төсөв 1,7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Үүний дагуу төлөвлөсөн зарцуулалтыг хийж гүйцэтгээд байна. | 100% | | |
| 49 | 103 | Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-09-02 Дугаар 2020_90 | 2. Төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбогдох, түүнийг ашиглах заавар, аргачлалыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.<br><br>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбогдох, түүнийг ашиглах заавар, аргачлалыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргаар батлуулан төрийн байгууллагууд, 9 дүүргийн засаг даргын тамгын газар болон 21 аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбогдох хүсэлтийг хүлээн авч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Дараах холбоосуудыг төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбосон. Үүнд: http://igovernment.mn/, https://eservice.ulaanbaatar.mn/, https://ehalamj.mn/,https://my.dulaan.mn/, http://earchive.mn/, http://www.ndaatgal.mn/, https://www.ezuvshuurul.mn/, https://license.crc.gov.mn/, http://tog.mn/, https://eyesh.eec.mn/, http://netcom.mn/mn, http://netcom.mn/mn, https://license.mofa.gov.mn/, http://www.mfa- | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | archives.mn/, https://evisa.mn/, http://burtgel.sme.gov.mn. | | | |
| 50 | 104 | Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020-11-18 Дугаар 2020_183 | 18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж гэрээт ажлын гүйцэтгэлийг түргэн шуурхай дүгнэж зохих санхүүжилтийг нэн дариу олгож ажиллав. | 100% | | |
| | 105 | | 19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 10.1 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлэн ажиллав. | 100% | | |
| | 106 | | 20. Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүртэл сунгахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүртэл сунгасантай холбогдуулан Тендер шалгаруулалтаар гэрээт ажлыг гүйцэтгэж байгаа компаниудын ажлын гүйцэтгэлийг 2020.12.25-ны өдрийн 10:00 цаг хүртэл хүлээн авахаар шийдвэрлэн ажилласан. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 51 | 107 | Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай 2020-11-23 Дугаар 2020_187 | 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын батлагдсан төсвийн хэмнэлтийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль үйлчлэх хугацаанд тухайн салбарын хэмжээнд цар тахалтай тэмцэх арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосугай.<br>Төсвийн зохицуулалтын батлагдсан хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар зохион байгуулж, төсвийн сахилга, хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | Тус газрын хувьд Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусаад байна. Нийт худалдан авалтын хувьд 260 сая төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд тус газрын хувьд онцгой нөхцөл байдлын зардалд зарцуулалт хийгээгүй болно. Батлагдсан төсвийн хэмнэлтийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль үйлчлэх хугацаанд тухайн салбарын хэмжээнд цар тахалтай тэмцэх арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах үйл ажиллагаа байхгүй тул төсвийн хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлэхээр ажиллав. | 100% | | |
| 52 | 108 | БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРГИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ 2020-11-29 Дугаар 2020_194 | 7. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан хязгаарлалтыг авч, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, бүх шатны боловсролын байгууллага, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | Тус газрын зүгээс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан хязгаарлалтыг авч, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, бүх шатны боловсролын байгууллага, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | 109 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-12-13 Дугаар 2020_211 | 5. Төрийн байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс бууруулахгүй, өөр зардалд шилжүүлэхгүйгээр цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шууд шилжүүлж байхыг төсвийн бүх шатны захирагч нарт даалгасугай. | Төрийн байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс бууруулахгүй, өөр зардалд шилжүүлэхгүйгээр цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шууд шилжүүлэн ажиллаж байна. | 100% | | |
| 54 | 110 | Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-12-23 Дугаар 2020_235 | 2. Сургалтын цахим технологийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хүртээмжтэй хэлбэрээр хөгжүүлэх, цахим контент боловсруулан сургалтад нэвтрүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай. | Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг сайжруулах зорилгоор тус газарт 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/19 тоот тушаалаар "Цахим ур чадвар, боловсролыг дэмжих" хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллав. Хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгүүдийг тодорхойлон, оролцогч талуудаас санал авч төлөвлөгөөнд тусгасан. Зорилтот бүлгүүдийн нэг нь: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний цахим ур чадварыг сайжруулахтай холбоотой сургалт, арга хэмжээ тусгагдсан болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах ажлын хүрээнд "НҮБ-ын accelerator labs"- болон "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөл"-ийн гишүүдтэй цахимаар уулзалт зохион байгуулсан байна. Үүний үр дүнд: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварын суурь түвшинг тогтоох судалгааны ажилд санал солилцсон бөгөөд судалгааны ажлын дараагаар | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулагдах сургалтын үе шатанд хамтран ажиллах шийдэлд хүрсэн. | | | |
| 55 | 111 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2020-12-30<br>Дугаар 2020_253 | 3. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын дүнд хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх;<br><br>1.2. Монгол Улсад короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тохиолдол бүртгэгдэж бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс шалтгаалан эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа 2020 онд хэрэгжиж дуусах боловч батлагдсан санхүүжилтийг бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн, мөн бусад салбарын зайлшгүй шаардлагатай болон Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоолын хүрээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний 2020 оны үлдэгдэл санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах. | Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төслүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэн ажиллаж байна. | 30% | | |
| | | | 2. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төслүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | захирагч нарт даалгасугай.<br><br>3. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай. | | | | |
| 56 | 112 | Жагсаалт батлах тухай<br>2021-01-15<br>Дугаар 2021_15 | 3. “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтад заасан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг урьд нь байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Тус газар нь бараа, бүтээгдэхүүн худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний хүрээнд зохион байгуулдаггүй болно. | 100%<br>Хяналтаас хасуулах | | |
| 57 | 113 | Түр хороо байгуулах тухай<br>2021-02-10<br>Дугаар 2021_29 | 4. Түр хороо, Ажлын шуурхай хэсгийг үнэн зөв, бодит мэдээллээр тухай бүр хангаж, мэдээ, мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх, нийтэд буруу ташаа, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх, тараасан бол холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Салбарын хэмжээнд КОВИД-19 халдварын цар тахалтай холбоотой хийж хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, ажлын талаарх мэдээллийг нэгдсэн байдлаар E-mongolia.mn портал системийн Covid-19 цэсээр дамжуулан хүргэж байна. Мөн буруу ташаа, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх дээр хяналт тавин ажиллаж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 114 | | 5. КОВИД-19 халдварын цар тахалтай холбоотой мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээ, мэдээллээр тогтмол, жигд хангах арга хэмжээ авахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай. | КОВИД-19 халдварын цар тахалтай холбоотой статистик мэдээлэл, цар тахлын эсрэг Засгийн газар, УОК -оос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөтөлбөр, зохицуулалтын мэдээллийг E-mongolia.mn портал системд Covid-19 цэс нээж, мэдээллийг түргэн шуурхай нийтэлж иргэдийг мэдээллээр хангаж байна. Коронавируст халдвар (ковид-19)-ыг хамтдаа даван туулахын тулд өдөр бүр хэрэгжүүлэх бидний 9 дадал мэдээллийг түлхэх мэдэгдлээр гаргаж вакцины гэрчилгээ болон олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ авах үйлчилгээнүүдийг нэмсэн. Вакцины QR кодыг үүсгэн, Covid19QRverify аппликейшинг хөгжүүлэн иргэдийг вакцинд хамрагдсан эсэхийг шалгах боломжийг бүрдүүлсэн. | 100% | | |
| 58 | 115 | Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-02-17 Дугаар 2021_43 | 1. Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай:<br>1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, | "2021 оны УИХ батлагдсан улсын төсвийг ХХМТГ нь ЗГ-с гаргасан тогтоол, дүрэм журмын хүрээнд үр дүнтэй , хэмнэлттэй зарцуулж ажилласан.<br>1.1. Тус газар нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэж ажиллаж байна.<br>1.2. Тус газар нь шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, орон тоог нэмэгдүүлээгүй батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаж байна.<br>1.3. Тус газар нь үйл ажиллагааны чиглэл, цар хүрээндээ төрийн байгууллагын нийтлэг жишгээр ангилан цалин хөлсийг нэмэгдүүлээгүй, шагнал, урамшуулал илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгоогүй ба зочин төлөөлөгч, томилолтын зардлыг хэмнэж ажилласан. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дунд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;<br>1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;<br>1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;<br>1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, | 1.4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусдаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авалтыг зохион байгуулж ажиллаагүй ба тэвчиж болохуйц зардлыг хэмнэж ажилласан.<br>1.5. Тус газар нь сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэж ажилласан.<br>1.6. Тус газар нь баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийн зардлыг хэмнэж ажилласан.<br>1.7. Тус газар нь цаг үеийн шинжтэй, мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зардлыг хэмнэж ажилласан.<br>1.8. Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний зардалд хэмнэлт гарган ажилласан.<br>1.9. Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хор зэрэгт хэмнэлт гарган ажиллаж байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;<br>1.5. салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;<br>1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;<br>1.7. хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;<br>1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах;<br>1.9. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах. | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 59 | 116 | "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл" батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58 | 3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай. | Тус газраас хөтөлбөрт хамрагдах сонирхолтой залуусыг цахимаар болон операторын системээр бүртгэлжүүлэхээр И-Монголиа /E-Mongolia/ цахим үйлчилгээний нэгдсэн системд нэмэлтээр хөгжүүлэлт хийж бүрэн ажиллагаанд оруулсан. Хөтөлбөрийн бүртгэлийн нөхцөл эцсийн байдлаар тодорхой болоогүй тул нэмэлт ажил хийгдээгүй болно. | 70% | | |
| 60 | 117 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_70 | 1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай:<br>1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбогдуулан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах;<br>1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүжилтийн шуурхай, нээлттэй, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан хангах, төсвийн тухайн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой | 1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбогдуулан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг цахим системд тухай бүр нь байршуулан ажиллаж байна. Төсвийн тухайн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.<br>1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг МУЗГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | анхаарах;<br>1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулж, гэрээ байгуулсан байхаар тооцож ажиллах;<br>1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлж ажиллах;<br>1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, хөрөнгийг бүртгэж, баталгаажуулахад онцгой анхаарч ажиллах;<br><br>1.6. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжид холбогдох гэрээ, хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах. | тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт болон Орон нутгийн өмчийн газарт тус тус эрхийг нь шилжүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд тус газрын төлөөллүүд орж ажиллан нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан. Тус газраас зохион байгуулах худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан ажиллаж байна.<br>1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлэн ажиллана.<br>1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, хөрөнгийг бүртгэж, баталгаажуулахад онцгой анхаарч ажиллана.<br>1.6. Өнгөрсөн онуудад зохион байгуулагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажилласан. | | | |
| 61 | 118 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай<br>2021-04-08<br>Дугаар 2021_93 | 5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | Тогтоолыг хэрэгжүүлэх асуудлыг хүрээнд байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажилласан. | 100%<br>Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ерөнхий сайдын захирамж | | | | | | | |
| 62 | 119 | Шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөө батлах тухай<br>2017-06-30<br>Дугаар 2017_119 | 2.. Шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад даалгасугай. | Шуудангийн тухай хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөө батлах нь Шуудангийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрхэд хамаарах болсон. Үүний дагуу 2021-2022 онд хэвлэгдэх шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөөг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/137 тоот тушаалаар батлуулсан. | 100%<br>Хяналтаас хасуулах | | |
| 63 | 120 | Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл байгуулах тухай<br>2017-11-28<br>Дугаар 2017_170 | 2.. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Бодлогын зөвлөлд үүрэг болгосугай: 2.1. Бодлогын зөвлөлийн ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан мөрдүүлэх; 2.2. Шаардлагатай бол тодорхой асуудлаар холбогдох бусад төрийн байгууллагын ажилтныг татан оролцуулж ажиллуулах; 3. Бодлогын зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хариуцуулсугай. | Энэ зөвлөлийн оронд Цахим хөгжлийн үндэсний хороо ажиллаж байна. 1.Яам, агентлаг, аймгуудын хэмжээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн тухай нэгдсэн мэдээллийг гаргах, дүн шинжилгээ хийх зорилгоор төрийн байгууллагуудаас судалгаа авч, дүнг нэгтгэв. Ерөнхий сайдын харьяа агентлагууд, Шадар сайдын харьяа агентлагууд, ЗГ-ын Хэрэг эрхлэх газар болон 13 яам, түүний харьяа агентлагуудын хэмжээнд 98 харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн төсөл, 930.261 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр, аймаг орон нутагт 51 төсөл 153,676 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжиж байна. Нэгтгэн үзвэл төрийн захиргааны төв болон 21 аймгийн хэмжээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нийт 149 төслийг 1,083.937 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.<br>2. Харилцаа холбооны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан эрхийн | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүрээнд ХХМТГ-ын газрын даргын 2019 оны 12 сарын 02 ны өдрийн А/158 тоот тушаалаар “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх олгох журам”, “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлал боловсруулах” ажлын хэсэг байгуулан журмын төслийг боловсруулж, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байрлуулж, олон нийтээс санал авч, төслийг газрын даргын тушаалаар батлуулсан.<br>3.Монгол Улсын 2019 оны 12 дугаар сарын 24 ний өдрийн 42 дугаар захирамжаар мэдээлэл, харилцаа холбооны дэвшлийг бүх нийтийн хүртээл болгох, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай хүртээмжтэй болгон цахимжуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, интернэт, цахим орчны ёс зүйн зөвлөмж боловсруулж мөрдүүлэн ажиллаж байна. | | | |
| 64 | 121 | Ажлын хэсэг байгуулах тухай /монгол бичгийн кодчилол, стандартыг боловсронгуй болгож олон улсын жишигт хүргэх асуудлыг зохион байгуулж хэрэгжүүлэх/ 2018-05-10 Дугаар 2018_95 | 2.. Монгол бичгийн кодчилол, стандарт, баримт бичгийг боловсронгуй болгох, дотоод, гадаадын байгууллага, судлаачидтай хамтран ажиллах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангаж, явц үр дүнг танилцуулан, Монгол бичгийн кодчилолыг олон улсын стандартын байгууллагаар батлуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг (Б.Чинбат)-т даалгасугай. | Ажлын хэсгийн 4 дүгээр хурлыг АНУ-ын Хосе хотноо 2020 оны 4 дүгээр сарын 3-5 болон 9 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтож байсан боловч цар тахлын нөлөөнөөс үүдэн цуцлагдсан. Юникодын консорциумын түвшинд монгол бичгийн ажлын хэсгийн хурлуудаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын дагуу монгол бичгийн юникодын дүрмийг (Unicode Technical Note, UTN) шинэчлээд байгаа. Уг дүрмийг ажлын хэсгийн 4 дүгээр хурлаар эцэслэн шийдвэрлэж Монгол бичгийн юникодын шинэчилсэн дүрэм бэлэн болно гэсэн хүлээлттэй байна. Монгол Улсын ажлын хэсэг Юникод консорциумын мэргэжилтнүүдтэй ажил хэргийн холбоотой ажиллаж байна. | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 122 | | 3.. Монгол бичгийн кодчилол, стандарт, баримт бичгийг боловсронгуй болгож олон улсын стандартын байгууллагаар батлуулах үйл ажиллагаатай холбоотой зардлыг санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Харилцаа холбооны зохицуулах хороо (С.Адъяасүрэн), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад даалгасугай. | Захирамжийн хүрээнд Монгол Улсын ажлын хэсгийн зүгээс монгол бичгийн компьютерын гарын байрлалын үндэсний стандартыг боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Уг стандартыг ойрын хугацаанд батлуулах, цаашлаад 2021 онд багтаан компьютерын үйлдлийн системийн томоохон үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнд (Windows, Mac OS, Linux гэх мэт) нэгтгэхээр ажиллаж байна. | 70% | | |
| 65 | 123 | Ажлын хэсэг байгуулах тухай 2019-04-24 Дугаар 2019_50 | 2.. Энэ захирамжийн 1-д заасан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам танилцуулж байхыг Ажлын хэсэг (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай. | Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам дээд шатны байгууллагад мэдээ хүргүүлэн танилцуулан ажиллаж байна. | 100% | | |
| 66 | 124 | Ажлын хэсэг байгуулах тухай 2020-02-21 Дугаар 2020_26 | 2.. Цахим орчинд иргэн үнэн, бодит мэдээлэл авах нөхцөлийг хангах, иргэдийн эрхийг хамгаалах, иргэдийг худал мэдээ мэдээллээс хамгаалах зорилгоор цахим орчны зохицуулалт хийх, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:<br>Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын дэд хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллахыг Ажлын хэсэг (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.<br>3. Энэ захирамжид заасан ажлыг хэрэгжүүлэх зорилгоор нарийвчилсан төлөвлөгөө баталж хэрэгжүүлэн, дүнг 2020 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай. | Иргэдийг худал мэдээллээс хамгаалах зорилгоор УИХ-ын гишүүд, Сайд, төрийн байгууллага (яам, агентлаг, эмнэлэг гм)-уудын албан ёсны Facebook хаягийг баталгаажуулсан (Фэйсбүүк компанийн баталгаажилтын цэнхэр тэмдэг (Verified Badge) авах хүсэлтийг илгээсэн.). Мөн тус баталгаажилтын цэнхэр тэмдгийг хэрхэн авах талаарх зөвлөмжийг боловсруулж тус баталгаажуулалтыг авахыг хүссэн иргэн, хуулийн этгээдэд цахим шуудангаар болон хэвлэмэл байдлаар хүргүүлж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | 125 | Төлөвлөгөө батлах тухай 2020-07-01 Дугаар 2020_99 | 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)"-г хавсралт ёсоор батлсугай.<br>2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд тус байгууллагын хүрээнд нийт 37 хүний орон тоотой ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн 53 хувь нь эмэгтэй, 47 хувь нь эрэгтэй албан хаагчтай ажиллаж байна. Удирдах түвшиний албан хаагчдын 80 хувь нь эрэгтэй, 20 хувь нь эмэгтэй албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. | 100% | | |
| **ЗГ-ын хуралдааны тэмдэглэл** | | | | | | | |
| 68 | 126 | 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 26 дугаар тэмдэглэл 2018-06-13 Дугаар 2018_26 | XIX.3. . Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор баталсан Төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>3.1. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан асуудлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь ирүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн | Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны талаар баримтлах бодлого-2025-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хяналтад авч төлөвлөгөөний хэрэгжилтэд /2020 оны байдлаар/ хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгов. | | | | |
| 69 | 127 | 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 5 дугаар тэмдэглэл 2019-01-23 Дугаар 2019_5 | XX.4. . Тус авто замын трасст орсон цахилгааны шугам, гэрэлтүүлэг, холбооны кабель, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээг шилжүүлэх, хүчитгэх, хамгаалах, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, авто замын барилгын ажлын талаар иргэдэд мэдээлэл өгөх ажлыг богино хугацаанд зохион байгуулж ажиллахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбат, Нийслэлийн Засаг дарга (Ж.Батбаясгалан)-д нарт тус тус даалгав. | "Гачууртын уулзвараас Налайх -Чойрын уулзвар хүртэлх 20,9 км авто замын дагуух холбооны дэд бүтцийг шилжүүлэх, тойруу холбоо зохион байгуулах, шинээр худаг сувагчлалын угсралт, суурилуулалт хийх" ажлыг ЗТХЯ болон салбарын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн дагуу улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, худаг сувагчлалын байгууламжийг ашиглалтад хүлээж авав. | 100% Хяналтаас хасуулах | | |
| 70 | 128 | 2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2019-05-29 Дугаар 2019_24 | XX.11. . "Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IY конгресс"-ын бэлтгэл ажлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан уг конгрессыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулах ажлын хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:<br>1.1. конгрессыг угтсан ажлын төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх; | Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IY конгрессыг зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүн ажиллаж, бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж, ажилласан. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 128 дугаар зарлиг, Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангах санаачилга гаргах;<br>1.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэлийг дэмжих, бараа бүтээгдэхүүний нь худалдан авах;<br>1.4. барилга, байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох. | | | | |
| 71 | 129 | 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2020-02-19 Дугаар 2020_11 | 3. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзоригт даалгав:<br>3.1. цахим орчинд иргэн үнэн, бодит мэдээлэл авах нөхцөлийг хангах, иргэдийн эрхийг хамгаалах, иргэдийг худал мэдээ мэдээллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх;<br>3.2. цахим орчинг ашиглах, түүний ашиглалтад хяналт тавихтай холбоотой журмын төсөл боловсруулах, батлах ажлыг зохион байгуулах;<br>3.3. домэйн нэрийн ашиглалт, зохицуулалттай холбоотой журмын төсөл боловсруулж батлуулах;<br>3.4. цахим орчинд худал мэдээлэл түгээх нөхцөлийг хязгаарлахтай холбоотойгоор байгууллага хоорондын ажлын уялдаа, зохион байгуулалтыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах; | 3.1-ийн хүрээнд Фейсбүүкийн баталгаажилтын цэнхэр тэмдэг буюу verified badge хэрхэн авах талаарх зөвлөмжийг боловсруулж төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага болон хувь хүмүүст уг зөвлөмжийг цахим шуудангаар хүргүүлэв. | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3.5. цахим орчин дахь нийгмийн сүлжээний хаяг, цахим хуудасны албан ёсны бүртгэлжүүлэлт хийх, хуурамч хаяг, цахим хуудсыг устгах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;<br>3.6. Фэйсбүүк компанитай хамтран ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч нэгдсэн удирдлагаар хангах. | | | | |
| 72 | 130 | 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2020-03-27 Дугаар 2020_21 | III.1. . 1. Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;<br>2. Үүрэг, даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсны үндсэн дээр эрх бүхий байгууллагад тайлагнах;<br>3. 2019 оны жилийн эцсийн байдлаар удаашралтай, гүйцэтгэл нь хангалтгүй байгаа үүрэг, даалгаврын шалтгааныг тодорхойлон хэрэгжилтийг эрчимжүүлэх, гүйцэтгэлийг | 2. Тус газар нь үүрэг, даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсны үндсэн дээр ЗГХЭГ-т тайлагнах үүргийн тухай бүх мөрдлөг болгон ажиллаж байна.<br>3. 2019 оны хувьд хэрэгжилт нь хангалтгүй гарсан ажлын хүрээнд тухайн ажлыг эрчимжүүлж хэрхэн богино хугацаанд хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллав. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайжруулах, шаардлагатай бол тухайн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх; 4. Хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй шийдвэр, заалтыг хяналтаас хасуулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд зохих тэмдэглэгээ хийж байх; 5. Төрийн эрх бүхий байгууллагууд хамтран баталж, хэрэгжүүлэх эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг тогтоосон хугацаанд нь батлан мөрдүүлдэг байх; 6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөлд тусгах харилцаа зохицуулалтыг урьдчилан судалж, үр нөлөөг тооцон, санхүү төсвийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, хэрэгжихүйц байхаар төлөвлөн боловсруулдаг байх; 7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд салбар, орон нутгийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайтар хангаж ажиллах. | 4. Хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй шийдвэр, заалтыг хяналтаас хасуулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд зохих тэмдэглэгээ хийн ажиллав. 5. Төрийн эрх бүхий байгууллагууд болон ХХЗХ-тай хамтран баталж, хэрэгжүүлэх эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг тогтоосон хугацаанд нь батлан мөрдүүлж шаардлагатай дүрэм журмыг шинэчлэн батлав. 6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөлд тусгах харилцаа зохицуулалтыг урьдчилан судалж, үр нөлөөг тооцон, санхүү төсвийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, хэрэгжихүйц байхаар төлөвлөн боловсруулж шинэчлэгдэн гарч байгаа хууль болон дүрэм журамд тооцооллыг боловсруулж ажиллав. 7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд салбар, орон нутгийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайтар хангаж шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах талаар санал хүргүүлж ажиллав. | | | |
| | 131 | | III.3.. 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов: 2.1. үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх; 2.2. үндсэн чиглэлд заасан зорилт, | Үндсэн чиглэлд тус газрын хариуцан гүйцэтгэх арга хэмжээнүүдийн биелэлтийг журмын дагуу үнэлж, төсөв хөрөнгийн мэдээллийн хамт тайлан гаргаж СЯ болон холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлж ажилласан. 2020 оны Үндсэн чиглэлийн 4 арга хэмжээг мөн энэ заалтыг баримтлан тайлагнаж байна. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэх. | | | | |
| 73 | 132 | 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2020-04-01 Дугаар 2020_22 | XYIII.2. . 2. Дараах арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:<br>2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах;<br>2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах;<br>2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх;<br>2.4. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь Монгол Улсын Сайд, Төсвийн ерөнхийлөн захирагч болон Харилцаа холбоо мэдээллийн технологийн газрын дарга нарын хооронд байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу төлөвлөлтийг гүйцэтгэж, байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилладаг. Хөрөнгө оруулалт, худалдан авах үйл ажиллагааг 2020 оны 2 сарын 01-нээс эхлэн хийхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу зар мэдээг 2020 оны 2 сарын 15-наас олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан. Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар нь 2020 онд нийт 7 төрлийн төсөл хөтөлбөрөөр ажил, бараа, зөвлөх үйлчилгээг авахаар 16,790,000,000 /арван зургаан тэрбум долоон зуун ерэн мянга/ төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд 16,524,295,400 / арван зургаан тэрбум таван зуун хорин дөрвөн мянга хоёр зуун ерэн таван мянга дөрвөн зуу/ төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнаж Сангийн яам болон ЗГХЭГ-т тухай бүр хүргүүлэн ажиллав.<br>Тус газар нь 2021 оны ажил, бараа, зөвлөх үйлчилгээг авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах. | | | | |
| 74 | 133 | 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 26 дугээр тэмдэглэл 2020-04-22 Дугаар 2020_26 | YII.. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуужуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгох; 2. Дулааны тоолуур худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт байгууллагын зарлагын хэмнэлт, давсан орлогоос холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэхийг Төсвийн захирагч нарт зөвшөөрөх; | Тус газар нь өөрийн гэсэн байргүй учраас Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн байранд байрлан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дулаан, цахилгаан гэх мэт урсгал зардлыг улирал бүр тогтмол төлж барагдуулан ажиллаж байна. | 100% Хяналтаас хасуулах | | |
| 75 | 134 | 2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 28 дугээр тэмдэглэл 2020-04-29 Дугаар 2020_28 | IX.3. . Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгах. | Төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан тусгуулсан бөгөөд нийт 24 сая төгрөгийг албан хаагчид олгуулаад байна. Мөн төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг тухай бүр олгон ажиллаж байна. Үүнтэй уялдуулан Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлд тус газрын саналыг тусгуулахаар ажиллаж байна. | 70% Хяналтаас хасуулах | | |
| 76 | 135 | 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдөр 29 дүгээр тэмдэглэл 2020-05-06 Дугаар 2020_29 | I.3. . Монгол Улс “Харилцаа холбооны салбар дахь бүс нутгийн хамтын нийгэмлэг”-т гишүүнээр элсэх хүсэлтийг зохих журмын дагуу уламжлах, тус байгууллагын гишүүний татварыг тухайн жилийн | Харилцаа холбооны салбар дахь бүс нутгийн хамтын нийгэмлэгт гишүүнээр элсэх хүсэлтээ албан ёсоор хүргүүлж, удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бүрэн эрхэт төлөөлөгчөөр элссэн, үйл ажиллагаанд нь оролцож байна. | 100% Хяналтаас хасуулах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэж байхыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад даалгах. | | | | |
| 77 | 136 | 2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09 Дугаар 2020_69 | Y.. Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав. | Төрийн үйлчилгээний цахим машинаар 35 нэр төрлийн үйлчилгээг 304,332 иргэдэд хүргэн ажиллалаа. Төрийн үйлчилгээний цахим машинд үйлчилгээ нэмэх боломжтой үйлчилгээний жагсаалтыг ТҮЦ машины талаарх лавлах үйлчилгээний утсанд ирсэн санал, нэг цэгийн үйлчилгээнээс иргэдийн хамгийн их авдаг төрийн үйлчилгээний судалгааны дагуу боловсруулсан.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 49 дугаар захирамжаар цахим орчны эрх зүйн орчныг бүрдүүлэхэд шаардлагатай хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргаар ахлуулан, ХЗДХ-ийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/225 тушаалаар "Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль"-ийг шинэчлэн найруулж "Нийтийн мэдээллийн тухай хууль"-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийг тус тус байгуулсан. Эдгээр ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд төрийн мэдээлэл, мэдээллийн сан, цахим харилцаа, мэдээллийн ил тод байдлын харилцааг зохицуулах "Нийтийн мэдээллийн тухай хууль"-ийн төслийг боловсруулан хуулийн | 70% | | |
| | | | | төслийн хэлэлцүүлгийг 2021-ний өдөр 2 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж иргэд, олон нийтийн саналыг авсны үндсэн дээр Засгийн газрын 2021 оны 3 дугээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шийдвэрлэсэн. Засгийн газраас гарсан шийдвэрийн дагуу уг хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр өргөн бариад байна. | | | |
| 78 | 137 | 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 74 дугаар тэмдэглэл 2020-12-30 Дугаар 2020_74 | XXIX.6. . Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр шинээр барих Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.42 км авто замын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр шинээр барих Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.42 км авто замын зурвас газарт байгаа цахилгаан, холбооны болон инженерийн бусад шугам сүлжээг шилжүүлэх, хүчитгэх, хамгаалах, барилга байгууламж, объектыг нүүлгэн шилжүүлж газар чөлөөлөх арга хэмжээг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор авч хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Замын трассын дагуу харилцаа холбооны сүлжээний зураглал, түр замын огтлолд орсон сүлжээг хамгаалах асуудлаар ЗТХЯ-ны дэргэд ажлын хэсэгт ажиллаж зурваст орсон сүлжээг хүчитгэх ажлыг хийсэн. | 100% | | |
| 79 | 138 | 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2021-02-10 Дугаар 2021_9 | XII.2. . Монгол Улсын Ерөнхий сайд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын дүнгийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж | 1.Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/119 дугаар тушаалаар "Технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффист гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. "Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд "Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв"-ийг байгуулах, цаашид удирдан зохион байгуулах, Инновацын тухай хуулийн дагуу мэдээллийн технологийн гарааны компанид татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах, дээд боловсролын салбарт мэдээллийн технологийн өндөр түвшний мэргэжилтэн бэлтгэх, Шинжлэх ухаан технологийн сангаар дамжуулан мэдээллийн технологийн компанийг дэмжих, "Боловсролын цахим шилжилт" арга хэмжээг хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлийн сургалтын агуулгыг нэмэгдүүлэх асуудлыг авч үзэж, зохих арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ) нарт даалгав. | ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих журам боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус газраас ажлын хэсэгт орж ажиллан журмын төсөл боловсруулахад шаардлагатай мэдээллээр ханган ажилласан. БШУЯ-аас журмын төслийн төсөлд санал авахаар ирүүлсэнтэй танилцан санал хүргүүлэхээр ажиллаж байна.<br>2.УИХ-ын гишүүн Г.Дамдиннямаар ахлуулсан төр хувийн хэвшлийн хамтарсан "Нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг сайжруулах" хөтөлбөр боловсруулах зорилго бүхий ажлын хэсэг нь ""Харилцаа холбоо, мэдээллийн технологийн хичээлд өөрчлөлт оруулах", "Тоон бичиг үсгийн боловсрол, ур чадварыг сайжруулах" хөтөлбөрт санал боловсруулах зэрэг чиглэлээр судалгааны ажил хийн гүйцэтгэн, санал боловсруулсан байна. Судалгааны ажлын хүрээнд: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр дахь нөхцөл байдалд судалгаа хийн, олон улсын туршлагыг (Австрали, Япон, Тайвань, Сингапур) судлан, харьцуулан, зөвлөмж гарган, судалгааны тайланг бэлтгэсэн. Мөн "Тоон бичиг үсгийн ур чадварын хүрээ"-ний олон улсын стандартын судалгааг хийн, Монгол Улсын тоон бичиг үсгийн чадварын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон, гол асуудал болон зорилго, зорилтоо тодорхойлсны дараагаар хэрэгжүүлэх арга хэмжээнд санал боловсруулсан байна. Судалгааны ажлын тайланг ажлын хэсгийн ахлагчид хүргүүлэхээр ажиллаж байна. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 139 | | XII.2. 2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн компанийг олон улсын зах зээлд гарахад нь төрөөс дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, гарааны бизнесийг дэмжих дундын хөрөнгө оруулалтын сан байгуулах чиглэлээр хувийн хэвшилтэй хамтарсан Ажлын хэсэг байгуулж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгав. | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын компаниудыг олон улсын зах зээлд гарахад төрөөс дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн анх дугаар хурлыг 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр тус газрын хурлын танхимд төр, хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулан хуралдааныг зохин байгуулав. Ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүн Х.Ганхуяг томилогдож тус ажлын хэсгийг 2 дэд ажлын хэсэгт хуваан судалгааны ажлыг эхлүүлсэн. Ажлын хэсгийн хүрээнд 3 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулсан. Мөн тус ажлын хүрээнд мэдээллийн технологийн 50 старт-ап компанийг оролцуулсан судалгаа авч судалгааны дүгнэлт гаргаж ажилласан. Дүгнэлтийг мэдээлэл технологийн компаниудын дунд танилцуулж нийтийн цахим хэлэлцүүлэг хийсэн. Хэлэлцүүлгээс гарсан санал дүгнэлтүүдийг нэгтгэж 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Төв шуудангийн 1111 төв дээр ажлын хэсгийн тайлан хүлээлцэх үйл ажиллагааны арга хэмжээг зохион байгуулж ажлын хэсгийн дэд багийн ахлагчид илтгэл тавьж санал дүгнэлт, холбогдох материалуудыг УИХ-ын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүн Х.Ганхуягт хүлээлгэн өгсөн.<br>2, “Нийгмийн хөгжлийн хөрөнгө оруулалтын сан байгуулах, санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах хүсэлтээ ирүүлсэн хувь хүн, аж ахуйн нэгжийн нийт 26 төлөөллийг оролцсон, УИХ-н гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны Г.Амартүвшин | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийн анх дугаар хурлыг 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд нийт 4 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулж, хувийн хэвшлийн төлөөллүүд болон технологийн старт-ап компаниуд төрөөс ямар асуудлын хүрээнд дэмжлэг хүсдэг талаар ярилцлага авах замаар судалгаа хийсэн. | | | |
| 80 | 140 | 2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14 | XII.3. 8. Аялал жуулчлалын салбарт зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, цахим хэлбэрт шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т; | Аялал жуулчлалын салбарт зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, цахим хэлбэрт шилжүүлэх талаар хамтран ажиллаж байна. | 70% | | |
| 81 | 141 | 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19 | II.. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов.<br>2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, хууль, тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав. | МУЗГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан "Шилэн кабельд холбох, 28 км /Архангай, Хашаат сум/", "Үүрэн холбооны сүлжээ /Ховд/", "Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Хөвсгөл, Арбулаг, Тариалан, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Эрдэнэбулган, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Төмөрбулаг, Цагаан-үүр сум/", "Харилцаа холбооны дахин дамжуулах станц /Увс, Өмнөговь сум, Улиаст баг/" төсөл, арга хэмжээнүүдийн техникийн тодорхойлолт болон шаардлагатай мэдээллийг боловсруулж Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, үнэлгээний хороонд тус газрын төлөөллүүд ажиллан худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу амжилттай зохион байгуулсан. "Дижитал-Эрдэнэт" төсөл /Орхон/ төсөл, | 70% | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | арга хэмжээний эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Холбогдох ажлын даалгаврыг боловсруулан ажиллаж байна. Тогтоолын 2 дугаар хавсралтад заасан "Шилэн кабельд холбох, зураг, төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/" төслийг Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газарт, "Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох "Олон талт түншлэл"" цахим хөтөлбөр /Орхон/" төслийг Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газарт тус тус эрхийг нь шилжүүлж, холбогдох ажлын даалгаврыг Засаг даргын тамгын газарт албан тоотоор хүргүүлсэн. Тус газраас "Харилцаа холбооны сүлжээний өргөтгөл /Өвөрхангай/" төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулж, үнэлгээний хороог байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | | | | |
| | 142 | | II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удаашрч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | Тус газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удаашрч байгаа төсөл, арга хэмжээ байхгүй болно. | 100% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 82 | 143 | 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2021-04-07 Дугаар 2021_22 | IX.3.2. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан цахим систем бүхий аргачлалын дагуу боловсруулах, холбогдох бэлтгэл ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан цахим систем бүхий аргачлалын дагуу боловсруулан | 100% | | |
| **ЗГ-ын албан даалгавар** | | | | | | | |
| 83 | 144 | Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03 | 1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчлан таниулах. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг төрийн банкны ПОС терминал, Monpay, QPAY, Social pay зэрэг арилжааны банкны интернэт төлбөр тооцооны хэрэгслүүдтэй холбон иргэдийн үйлчилгээний төлбөрийг төлөх боломжийг бүрдүүлсэн. Мөн Монгол банк, Ebarimt системтэй холбогдсон. | 70% | | |
| | 145 | | 1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх. | "Монгол Улсад цахим гарын үсгийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл"-ийн 3.8 дахь заалтыг үндэслэн тус газраас Үндэсний Дата Төв УТҮГ-т Төрийн гэрчилгээжүүлэх байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосноор төрийн гэрчилгээжүүлэгч байгууллагын үүргийг гүйцэтгэн төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгож байна. Төрийн байгууллагууд Төрийн гэрчилгээжүүлэх байгууллагатай бүртгэлийн нэгжийн гэрээ байгуулан тоон гарын үсэг авах боломж бүрдэж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлсэн. | 100% | | |
| | 146 | | 1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах. | Төрийн үйлчилгээний нэгдсэн системд орсон үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа, үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх лавлагаа зэрэг үйлчилгээнүүдийн шимтгэл төлөлтийг | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | буурулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, иргэн (даатгуулагчид) нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа үйлчилгээг үнэгүй болгосон. | | | |
| | 147 | | 1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах. | Тус газраас Цахим засаглал үндэсний хөтөлбөрийг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 73 дугаар тоот тогтоолоор батлуулж 2019-2020, 2021-2022 2 үе шаттай хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд ТҮЦ машин, e-mongolia.mn портал болон апликейшнаар дамжуулан төрийн 527 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. | 100% | | |
| | 148 | | 3.. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia.mn платформд ПОС терминал, QPAY, Монpay, ebarimt, Монгол банкны картын систем, арилжааны банкны мобайл аппликейшн болон интернэт банк ашиглан үйлчилгээний төлбөр төлөх боломжийг бүрдүүлсэн. | 100% | | |
| 84 | 149 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 | 1. Дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:<br><br>1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн | 1.9 мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүртэх хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон зорилтот бүлгийн нийгмийн тэгш оролцоог бүрдүүлэх зорилгоор тусгай техник, программ хангамж нэвтрүүлэх, контентоор хангах;<br>•Хөгжлийн бэрхшээлтэй хүний цахим хуудасны хүртээмжийг сайжруулах олон улсын аргачлал (Web Content Accessibility Guidelines), IPTV системийн үйлчилгээний | 70% | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; | хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлалыг Монгол хэл дээр орчуулан хэвлүүлж, бүх төрийн байгууллага болон веб сайтын үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн. Энэхүү олон улсын аргачлалын дагуу төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн шат дараалсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ""Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай"" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, саналуудыг тусгаж эцэслээд 3 дугаар сарын 17-ны өдрийн 1/249 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-аас яамд, төрийн захиргааны байгууллагуудад зөвлөмж хэлбэрээр чиглэл өгсөн. | | | | |
| | 150 | | 1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх; | Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “e-mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтыг төрийн байгууллагуудаас ирүүлсний дагуу 2021 оны 6 сарын байдлаар 527 үйлчилгээ оруулаад байна. | 100% | | | |
| | 151 | | 1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх; | Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх ажлын хүрээнд 9 аймгийн 108 сумдад, Улаанбаатар хотын 6 дүүргийн алслагдсан 51 хороодын төрийн албан | 100% | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хаагчдад төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх сургалтыг цахимаар болон байгууллага дээр нь зохион байгуулж, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системийг иргэдэд таниулан сурталчлах, ашиглах зааварчилгаа өгч, орон нутгийн болон алслагдсан хороодын иргэдэд e-mongolia системийн хэрэглээний талаарх мэдлэг, чадвар олгох сургагч багш бэлтгэсэн. Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийн хөгжүүлэлтийн ажил дуусаж, суурилуулалт, жигдрүүлэлт, сайжруулалтын ажлууд үргэлжилж байна. ERP системийг дараах төрийн байгууллагууд ашиглаж эхэлсэн. Үүнд: Увс, Сүхбаатар, Хэнтий, Дундговь, Өвөрхангай, Дорноговь аймгийн ЗДТГ, Үндэсний дата төв, Мэдээллийн технологийн үндэсний парк, Монголын цахилгаан холбоо ХК, Радио телевизийн үндэсний сүлжээ, Нислэгийн цаг уурын төв, Монгол шуудан ХК, Цаг уур орчны шинжилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах газар, Туул голын сав газрыг хамгаалах газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн төв, Шинэ нисэх буудал ТӨХХК, Харилцаа холбооны зохицуулах хороо, Барилгын политехник коллеж, Соёлын яам, БОАЖЯ, Спортын анагаах ухаан эрдэм шинжилгээний төв, Санхүүгийн зохицуулах хороо, МБИС. | | | |
| | 152 | | 1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, | Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч байгаа лавлагаа тодорхойлолтыг иргэн, хуулийн этгээд өөрийн эрхээр ороод шалгах боломжийг бүрдүүлсэн. Лавлагаа тодорхойлолтын хүчинтэй байдал, агуулга зэргийг шалгах боломжтой. Мөн Вакцины | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх; | QR кодыг үүсгэн, Covid19QRverify аппликейшинг хөгжүүлэн иргэдийг вакцинд хамрагдсан эсэхийг шалгах боломжийг бүрдүүлсэн. | | | |
| | 153 | | 1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн операторын системд нэвтрэх, үйлчилгээний хүсэлт үүсгэх, баталгаажуулах үйлдлүүдийг тоон гарын үсгийг ашиглан хийж байна. ТҮНС -ээс хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд нь өөрийн тоон гарын үсгийг ашиглан хуулийн этгээдтэй холбоотой лавлагаа, тодорхойлолт, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн. | 100% | | |
| | 154 | | 1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах; | Танилт нэвтрэлтийн Дан системд Голомт, Худалдаа хөгжлийн банк, Төрийн банкны интернэт банкны эрхээр нэвтрэх боломжтой болсон. Бусад арилжааны банкнууд холбогдох хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна. | 70% | | |
| | 155 | | 1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах; | Төрийн байгууллагуудаас үзүүлэх үйлчилгээнүүдийг цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан хүргэх ажлууд дээр байнгын дэмжлэг туслалцааг үзүүлэн ажиллаж байна. Манай газраас хэрэгжүүлж буй Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон мобайл аппликейшнээр дамжуулан төрийн 527 үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээний www.e-Mongolia.mn системийг 2021 оны 6 дугаар сарын байдлаар 1.6 сая хүн хэрэглэж байна. | 100% | | |
| | 156 | | 1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | Тус газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/139 дүгээр тушаалаар баталсан "E-MONGOLIA төрийн үйлчилгээний цахим систем болон мобайл системийг олон нийтэд таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд олон нийтийн сүлжээнд сошиал постор, баннер, видео контент байршуулах, телевизүүдээр мэдээ явуулах, нийтлэл ярилцлагыг цахим сайтуудад байршуулах, брошюр тараах зэрэг ажлуудыг үе шаттайгаар хийгээд байна. Мөн E-Mongolia төрийн цахим үйлчилгээг алслагдсан хороодын иргэд болон хороодын албан хаагчдад сурталчлах, таниулах ажлын хэсгийн байгуулан ажиллаж байна. | | | |
| | 157 | | 1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг "Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем"-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | Архивын ерөнхий газартай хамтран цахим баримт бичиг солилцооны дундын системийг бий болгох шийдэлд хүрч, албан хэрэг хөтлөлтийн систем хоорондын харилцан холболтын гарын авлагын төслийг боловсруулсан. Цахим баримт бичиг солилцооны дундын системийг Үндэсний дата төв УТҮГ-ын зохиомол серверт шилжүүлэн байршуулсан. Төрийн захиргааны болон төрийн өмчийн, орон нутгийн захиргаа, түүний харьяа 1206 байгууллага, Нийслэлийн нутгийн захиргааны 1697 байгууллага цахим хэлбэрээр албан бичиг солилцох боломжтой болсон. Дээр дурдсан системтэй Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар хөгжүүлсэн Docx албан хэрэг хөтлөлтийн дундын системийг холбох хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна. | 70% | | |
| 85 | 158 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 | 4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн найдвартай хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн нууцлал, системийн аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах, албан даалгаврын хэрэгжилтийг байгууллага бүрээр нэгтгэн, тайланг | Төрийн үйлчилгээний нэгдсэн портал (www.e-mongolia.mn), төрийн үйлчилгээний операторын систем (www.operator.e-mongolia.mn), төрийн үйлчилгээний нэгдсэн мобайл аппликейшныг хөгжүүлэн 103 төрлийн нэг шатлалт (лавлагаа тодорхойлолт, татвар төлөлт), 156 төрлийн | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт танилцуулж байхыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т. | олон шатлалт үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн 258 төрийн үйлчилгээнүүдийг холбоосоор холбон нэвтрүүллээ. Үндсэн системтэй холбоотой нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалтын ажлууд тасралтгүй хийгдэж байна. | | | |